

АГУУЛГА

**НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ
ТАНИЛЦУУЛГА 3**

<i>ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i>	5
<i>ГУРАВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i>	7
<i>3.1. Орчны тохижилт</i>	7
<i>3.2. Ногоон байгууламж</i>	8
<i>ДӨРӨВ. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i>	10
<i>ТАВ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i>	11
<i>5.1. Хатуу хог хаягдал</i>	11
<i>5.2. Шингэн хог хаягдал</i>	14
<i>ЗУРГАА. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ</i>	15
<i>ДОЛОО. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i>	18
<i>НАЙМ . ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</i>	21
<i>ДҮГНЭЛТ</i>	22

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Хатуу хучилттай явган хүний зам, тоглоомын талбай	7
Зураг 2. Жуулчны баазын цэцгийн мандал	7
Зураг 3. Мод ургасан байдал	9
Зураг 4. Усалгаанд ашигладаг савнууд.....	9
Зураг 5. Жуулчны баазын хатуу хаягдлын түр цэг	11
Зураг 6. Хуванцар болон шил лааз ангилаж хуримтлуулсан байдал	11
Зураг 7. Хуруу зай болон автомашины хаягдал дугуйг хуримтлуулсан байдал	12
Зураг 8. Жуулчны баазын эргэн тойронд их цэвэрлэгээ хийсэн байдал	13
Зураг 9. Бохир соруулж буй байдал.....	14
Зураг 10. Агаарын шинжилгээ хийлгэж буй байдал	15
Зураг 11. Ургамлан бүрхэвчийг доройтуулалгүй нөхөн сэргээж ашигласан байдал	17
Зураг 12. Баазын хашаанд туулай явж буй нь.....	17
Зураг 13. Газар чөлөөлөхөөс өмнөх үеийн байдал.....	18
Зураг 14. Газар чөлөөлсөн байдал.....	19

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын гүйцэтгэл	22
---	----

**НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ
ТАНИЛЦУУЛГА**

“Хөх чоно гурав” ХХК-ийн “Хос хэрэм жуулчны бааз” нь Улаанбаатар хотоос 44 км зайд Налайх дүүргийн 1-р хорооны нутаг дэвсгэрт Горхи Тэрэлжийн Байгалийн цогцолборт газарт Тэрэлжийн гүүрний зүүн хойд талд байрладаг.

“Хөх чоно гурав” ХХК нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт жуулчны баазын зориулалтаар 1.3 га талбайд газар эзэмших зөвшөөрөл авсан бөгөөд газар ашиглах гурвалсан гэрээг Горхи-Тэрэлжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаа, Налайх дүүргийн засаг даргатай 5 жилийн хугацаатай хийж энэ онд гурвалсан гэрээг дүгнүүлэн газар ашиглах эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулсан.

“Хос хэрэм” амралт нь Туул голын дэнжид байрладаг бөгөөд цэвэрхэн тохилог тус амралтанд албан байгууллага, анги хамт олон, найз нөхөд, гэр бүлээрээ ирж Горхи Тэрэлжийн үзэсгэлэнт байгальд эрүүл цэвэр агаарт тав тухтай амрах бүх нөхцлийг бүрдүүлсэн. “Хөх чоно гурав” ХХК нь жуулчны баазын зориулалттай 1.3 га талбайд зориулалтын дагуу аялагчид амрах байр, сууц, гэр болон бусад объектуудыг барьж байгуулсан. Амрагчдын тав тухыг хангаж бойлуур суурилуулан халуун усны асуудлыг шийдсэн нийт 26 өрөө бүхий тохилог дулаан байшингууд дотроо 00 душтэй бөгөөд бүрэн тавилгатай 10 монгол гэртэй мөн 2 өрөөнд иж бүрэн засвар хийсэн.

Амрагчид чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх хүүхдийн тоглоомийн талбай, задгай асар, сагсан бөмбөгийн талбай, элсний волейбол, караоке, ширээний теннис, билльярдтай. Мөн амралтын газрын ресторанаар үйлчлүүлж эрүүл агаарт найз нөхөдтэйгээ хорхог, боодог, шорлог, уламжлалт монгол хоол хийлгэн амрах боломжтой.

“Хос хэрэм” жуулчны бааз нь нэг ээлжиндээ 80 орчим амрагчдыг хүлээн авах хүчин чадалтай бөгөөд амралтын газрын дарга, зохион байгуулагч, тогооч, бэлтгэгч, зөөгч, бармен, 2 туслах ажилчин нийт 8 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна.

2022 онд 2000 орчим үйлчлүүлэгч хүлээж авах төлөвлөгөөтэй ажилласан ч улс орны нийгэм эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотойгоор төлөвлөсөн тооны үйлчлүүлэгчид авах нөхцөл боломж бүрдээгүй.

2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланд байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд, орчны хяналт

“ХОС ХЭРЭМ” ЖУУЛЧНЫ БААЗЫН 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын хамт тайлагнасан болно.

“Хос хэрэм” жуулчны баазын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг үндэслэн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаал “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулав.

ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хос хэрэм жуулчны бааз нь тайлант онд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.

- Жуулчны баазын байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайланг батлуулсан
- Байгаль орчны аудит хийлгэсэн
- Эзэмшил газрын дотогш татсан хэсэгт байрласан объектыг зөөвөрлөн холдуулсан
- Хөрс, ургамал нөмрөгийг талхлахгүй байх, алдрал, эвдрэлд өртсөн хөрс, ургамлыг байнга нөхөн сэргээж шинээр мод тарьсан.
- Ахуйн аливаа хог, бохир усыг ил задгай хаяхгүй байх талаар анхаарч ажилласан.
- Галын хор, багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг үе шаттай шалган, хэвийн түвшинд байлгаж ажилласан,
- “Хос хэрэм” жуулчны бааз нь агаарын бохирдлыг бууруулах зорилгоор жуулчны баазын гал тогооны хэрэглээнд 2017 оноос газ хэрэглэж байгаа ба “Дашваанжил” ХХК-тай хамтран ажиллах гэрээг сунгуулан ажиллаж байна.
- Жуулчны баазын барилга байгууламжгүй хэсгийн хөрс, ургамлыг хамгаалахын тулд авто зогсоол, явган хүний зам талбайг хайрган хучилттай болгож, тоглоомын талбайг цементлэсэн тул агаар орчин бохирдохгүй.
- Жил бүр амрагчдын байрны урд болон зам дагуулан цэцгийн мандал байгуулж, мод, бут сөөг тарьсан нь сайн ургаж байна.
- Газар ашигласан төлбөрөө төлж тооцоо нийлсэн акт үйлдсэн.
- Тайлант 2022 онд байгалийн болзошгүй аюул осол/газар хөдлөлт, усны үер, салхи шуурга, аянга цахилгаан, гал түймэр, үйлдвэрлэлийн осол, халдварт өвчин тархах г.м/ гарч жуулчны баазын үйл ажиллагаа, ажилчдын эрүүл мэндэд хохирол учруулаагүй болно.
- Төслийн үйл ажиллагаанаас гарч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахад шаардагдах зардлыг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд жил бүр тусган хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах талаар хийсэн ажлыг холбогдох газруудад тайлагнаж байна.
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээнүүдийг

тайлант онд авч хэрэгжүүлсэн.

- Горхи-Тэрэлжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаа, Налайх дүүргийн ЗДТГ, 1-р хорооны Засаг дарга, Мэргэжлийн хяналтын газар, НБОГ, БОАЖЯ болон засаг захиргааны байгууллагуудтай харилцаа холбоотой ажиллаж байгаль хамгаалах арга хэмжээнүүдийг авч ажилласнаар байгаль орчинд болон, ажилчдын эрүүл мэндэд ямар нэгэн сөрөг нөлөөлөл үзүүлээгүй болно.

ГУРАВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

3.1. Орчны тохижилт

“Хос хэрэм” жуулчны бааз нь газар эзэмших зөвшөөрөлтэй талбайг бүрэн хашаажуулсан хөрсний эвдрэл, бохирдлыг бага байлгах, унаган төрх байдал алдагдахаас сэргийлж 2022 онд дээр явган хүний зам, автомашины зогсоолын талбайг арчлан тордож, хөрсний эвдрэл, бохирдлоос сэргийлж ажилласан.



Зураг 1. Хатуу хучилттай явган хүний зам, тоглоомын талбай

Өмнөх онд эзэмшил газрын сул чөлөөтэй талбайг үр ашигтай ашиглах, орчны тохижилтыг хийж автомашины зогсоол байгуулж тэмдэгжүүлэн явган хүний зам болон тоглоомын талбайг хатуу хучилттай болгосон учраас тайлант онд нэмж хатуу хучилт хийгдээгүй.

Харин жуулчны баазын цэцгийн мандалд цэцэг тарьсан.



Зураг 2. Жуулчны баазын цэцгийн мандал

Цаашид амралтын газрын хашаанд шинээр хөрсөн бүрхэвч элэгдэл, эвдрэлд өртөхөөргүй болсон.

3.2. Ногоон байгууламж

Жуулчны баазын тав тухтай, эрүүл орчныг бүрдүүлэх зорилгоор өмнөх онуудад 136 модоор хашаалсан бол 2022 онд нэмж шинээр 118 мод тарьсан.

Үүнээс:

Улиас-100ш, Хайлаас-40ш,

Бургас-40ш, Агч-5ш,

Гацуур-1ш, Чацаргана-30ш,

Монос-35ш, Гүйлс-3ш тарьсан байна.

Нийт 254 ширхэг мод тарьснаас ургалт 80 орчим хувьтай, ногоон байгууламжийн арчилгаа тордолтыг сайн хийж услаж, ургуулах ажлыг ажилчдад хариуцан ажилласан.





Зураг 3. Мод ургасан байдал

Ногоон байгууламжийн усалгаанд нөөц савнууд суурилуулж усалтын систем байгуулсныг 2022 онд хэвийн ажиллуулсан.



Зураг 4. Усалгаанд ашигладаг савнууд

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт ногоон байгууламжийн тайлан гаргаж хүргүүлсэн.

**ДӨРӨВ. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

“Хос хэрэм” жуулчны бааз байрлаж буй газар нь Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт харъяалагдана. Жуулчны баазын эзэмшил талбайд түүх соёлын ямар нэгэн дурсгал илрээгүй. Иймд уг төслөөс түүх соёлын өвийг хамгаалах ажил хийгдээгүй болно.

ТАВ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

5.1. Хатуу хог хаягдал

Хог хаягдлын төлбөрийг Налайх дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 33 тоот тогтоол, Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн 12 тоот тогтоолын дагуу үйлчилгээний хөлсийг тооцож Налайх дүүргийн татварын хэлтэст тушаасан.

Хог хаягдлын гэрээг Налайх дүүргийн “НАЛАЙХ ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ” ОНӨААТҮГ-тай 2022 оны 05 сарын 26-ны өдрөөс 4 сарын хугацаагаар сунгалт хийсэн.

Манай компани 2022 оны үйл ажиллагаандаа Хог хаягдлын тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөн зориулалтын цэгээс өөр газарт хог хаягдал хаяхгүй байх, хог хаягдлыг ангилан ялгаж тээвэрлэгчид хүлээлгэн өгөх зэрэг арга хэмжээ авч ажилласан.



Зураг 5. Жуулчны баазын хатуу хаягдлын түр цэг



Зураг 6. Хуванцар болон шил лааз ангилаж хуримтлуулсан байдал

Жуулчны баазын үйлчилгээнд ашиглаж буй машин техникийг засвар үйлчилгээ засварын газарт хийлгэж тосыг солиулсан.

Харин хуруу зай, дугуй, будгийн материал зэрэг цөөн тооны аюултай хог хаягдал гарч болзошгүй тул тусад нь хадгалж хог тээвэрлэгч байгууллагад хүлээлгэж өгнө.



Зураг 7. Хуруу зай болон автомашины хаягдал дугуйг хуримтлуулсан байдал

Мөн улирал бүр нийтийн цэвэрлэгээ хийж хог хаягдлыг цэвэрлэдэг ба хог хаягдлын гэрээний сунгалтыг хийлгэж төлбөрийг төлсөн.



Зураг 8. Жуулчны баазын эргэн тойронд их цэвэрлэгээ хийсэн байдал

5.2. Шингэн хог хаягдал

“Хос хэрэм” жуулчны бааз нь 7.0 м³ багтаамжтай бохир усны цооногтой, доторлогоотой соруулдаг нүхэн жорлонтой ба үйл ажиллагаанаас гарсан шингэн хаягдлыг байгальд халгүй байдлаар соруулан зайлуулдаг.

“Хос хэрэм” жуулчны бааз нь аж ахуйн нэгж байгууллагын бохир ус татан зайлуулах гэрээг 2022 оны 07 сарын 05-ны өдөр “Чандмань Налайх” ОНӨААТҮГ-тай 1 жилийн хугацаатай гэрээ хийж хамтран ажилласан.

Манай бааз зөвхөн дулааны улиралд ажилладаг тул сар бүр шингэн хаягдлаа бохир соруулах машин дуудаж зайлуулсан. Мөн ариутгал халдваргүйтгэл тогтмол хийлгэж ажилласан.




Зураг 9. Бохир соруулж буй байдал

Жуулчны баазын үйл ажиллагааг явуулахдаа ургамлан нөмрөг хамгаалах арга хэмжээг тогтмол авч ажилладаг ба тайлант онд нэмж мод, бут тарьсан. Эзэмшил газар дахь ургамлан нөмрэгийг доройтуулалгүй ашигласан ба ойн мэргэжилтнээс зөвлөгөө авч жуулчны баазын ногоон байгууламжийг нэмэгдүүлэн ажилласан.



Зураг 11. Ургамлан бүрхэвчийг доройтуулалгүй нөхөн сэргээж ашигласан байдал
Мөн баазын үйл ажиллагаанаас амьтны шилжилт хөдөлгөөнд саад учруулахгүйг хичээн ажилладаг ба баазын хашаанд бор туулай явах нь элбэг тохиолддог. Харин хашааны гадна талаар өөр төрлийн амьтан ажиглагдаагүй.



Зураг 12. Баазын хашаанд туулай явж буй нь

ДОЛОО. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Хөх чоно гурав” ХХК нь Монгол улсын хууль эрхзүйн хүрээнд хийгдэх байгаль орчны тайлан, төлөвлөгөө, татвар хураамжуудыг цаг тухайд нь төлөх, хог хаягдлыг багасгах, бууруулах, ангилан хаях, усыг зохистой хэрэглэж, хэмнэх зэргээр байгууллагын хэмжээнд холбогдох арга хэмжээнүүд авч ажилласан.

Жуулчны баазын газар урд талаараа усны хамгаалалтын бүстэй давхцсан тул БОАЖЯ-ны Ой, ус, тусгай хамгаалалттай газрын кадастрын хэлтсээс эргэлтийн цэгт өөрчлөлт оруулж давхацсан хэсэгт байрлах объектыг буулган нүүлгэж газар чөлөөлсөн.



Зураг 13. Газар чөлөөлөхөөс өмнөх үеийн байдал



Зураг 14. Газар чөлөөлсөн байдал

Эзэмшил газрын дотогш татсан хэсэгт байрласан объектыг зөөвөрлөн холдуулсан. Харин шалны цементэн хэсгийг ирэх хавар ховхлон авч нөхөн сэргээлт хийн Горхи-Тэрэлжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаанд хүлээлгэн өгнө.

Мөн Ой, ус, тусгай хамгаалалттай газрын кадастрын хэлтсээс усны сан бүхий газрын онцгой, энгийн хамгаалалтын бүс болон Ойн сан бүхий газартай давхцалгүй лавлагааг гаргуулсан.

MNS 6426:2013 “Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц, үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” Монгол Улсын стандартын дагуу үйл ажиллагаа явуулсан бөгөөд удирдлага зохион байгуулалтын ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Байгаль орчны төлөвлөгөөт аудитын мэргэжлийн байгууллага “Өртөөлөн” ХХК-аар хийлгэсэн.
- Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайланг БОАЖЯ-аар баталгаажуулсан 2022-2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулсан.
- Газрын төлбөр тооцоог бүрэн төлж газар ашиглах гурвалсан гэрээг дүгнүүлэн газар ашиглах №485 дугаартай гэрчилгээг БОАЖЯ-аар 2027 он хүртэл сунгалт хийлгэсэн.
- Налайх дүүргийн Засаг даргатай Хамтран ажиллах гэрээг дүгнүүлэн 2022 оны 08 сарын 17-нд сунгалт хийлгэсэн.
- Ахуйн шавьж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэлт хийх тухай гэрээг 2022 оны 06 сарын 08-нд “Нандин-Өргөө” ХХК-тай байгуулсан гэрээг сунгуулж ажилласан,
- Хог хаягдлыг ачиж тээвэрлэх гэрээг Налайх дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-тай 2022 оны 05 сарын 26-нд 4 сарын хугацаатай сунгуулан хийсэн,
- Аж ахуйн нэгж байгууллагын бохир ус татан зайлуулах гэрээг 2022 оны 07 сарын 05-нд “Чандмань Налайх” ОНӨААТҮГ-тай 1 жилийн хугацаатай гэрээ байгуулсан,
- Горхи-Тэрэлжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаа, Налайх дүүргийн ЗДТГ, Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн БОГ болон засаг захиргааны байгууллагуудтай байнгын харилцаа холбоотой ажилласан;
- Ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлтийг 2022 оны 07 сард Усны газраар гаргуулсан ба 08 сард Ус ашиглах эрхийн бичгийг сунгуулж, ус ашиглах гэрээ байгуулсан.
- Хог хаягдлыг багасгах, бууруулах, ангилан хаях, усыг зохистой хэрэглэх талаар ажилчдад сургалт зохион байгуулж, жуулчны баазад анхааруулга, санамжуудыг байрлуулсан.
- Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж байгууллагын дотоод дүрэм журам, анхааруулга, санамжийг мөрдөж ажилласан.

**НАЙМ . ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД,
ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2022 онд гүйцэтгэсэн ажлын тайлан болон баазын ногоон байгууламжийн тайланг Горхи-Тэрэлжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаанд тайлан хэлбэрээр гаргаж өгсөн. Мөн Нийслэлийн Байгаль орчны газарт тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг дүгнүүлэхээр хандаад байна.

ДҮГНЭЛТ

“Хос хэрэм” жуулчны бааз нь 2022 онд 2000 орчим хүн хүлээж авах төлөвлөгөөтэй ажилласан боловч тайлант онд төлөвлөгөөнд хараахан хүрээгүй болно. Налайх дүүргийн худалдаа, үйлчилгээний зөвлөлтэй байгуулан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 2021 оны 08 сарын 19-ны өдөрөөс 1 жилийн хугацаатай авч сунгуулахаар хүсэлт хүргүүлсэн.

Налайх дүүргийн 1-р хорооны Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулан нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажилласан.

Мөн жуулчны баазын байгаль хамгаалах чиглэлийн ажлуудыг орхигдуулалгүй хийсэн. Тайлант онд жуулчны баазын байгаль орчны төлөвлөгөөт аудит, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлан болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖЯ-аар баталгаажуулан мөрдөж ажиллаж байна.

Хүснэгт 1. 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын гүйцэтгэл

№	Зардлын ангилал		Төсөв, мян.төг
1.	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Агаарын бохирдлыг бууруулахад хийн түлш	250.0
		Газар ашигласны жилийн төлбөр	450.0
		Усны шинжилгээний төлбөр	100.0
2.	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлт	Ногоон байгууламжийн арчилгаа, мод нэмж тарих	200.0
3.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт		-
4.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	Хог хаягдлын төлбөр	140.0
5.		Бохир соруулах төлбөр	198.0
6.	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт		8300.0
7.	Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр		240.0
8.	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах		50.0
Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн нийт төсөв, мян.төг			

“Хөх чоно гурав” ХХК-ийн Хос хэрэм жуулчны бааз нь 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэд 9928.00 мянган төгрөг зарцуулсан байна.